

**Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт өртсөн  
хүүхэдтэй ажиллах нь**

***Цагдаагийн ажилтануудад зориулсан гарын авлага***

**Гарчиг:**

Оршил  
Гарын авлагын танилцуулга

**БҮЛЭГ 1**

1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл
  - 1.1. хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний төрөл ангилал
  - 1.2. хохирогчийн эрх, үүрэг, сэтгэлзүйн онцлог
  - 1.3. хохирогчоос мэдүүлэг авах өрөөг ашиглах
  - 1.4. хүчирхийлэлд өртсөн хүүхдээс мэдүүлэг авахад цагдаагийн ажилтны баримтлах зарчим

**БҮЛЭГ 2**

2. Биеийн хүчний хүчирхийлэл, илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт
  - 2.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур
    - анхны уулзалт, ярилцлага
    - хэргийн талаар ярилцах
    - гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
    - хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
    - цаашид авах арга хэмжээг төлөвлөх
  - 2.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа
  - 2.3. ОУ-ын хууль тогтоомж

**БҮЛЭГ 3**

3. Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт
  - 3.1. Хүчингийн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн халдлагын ялгаа
  - 3.2. Хүчингийн гэмт хэргийн үйлдэгдэх онцлог
    - садист
    - догшин
    - хуурч мэхлэх
  - 3.3. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур
    - анхны уулзалт, ярилцлага
    - хэргийн талаар ярилцах
    - гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
    - хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
    - цаашид авах арга хэмжээг төлөвлөх
  - 3.4. Хүчингийн гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх туслалцаа

#### **БҮЛЭГ 4**

4. Сэтгэл санааны, үг хэлээр доромжлох хүчирхийлэлийн илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт

4.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

4.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа

#### **БҮЛЭГ 5**

5. Эдийн засгийн болон гэр бүлийн хүчирхийллийн илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт

5.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

5.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа

#### **БҮЛЭГ 6**

6. Үл хайхрах /neglect/ хүчирхийлэл илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт

6.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

6.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа

7. Зарим хууль тогтоомжоос

- I. МУ-ын Үндсэн хууль
- II. МУ-ын Гэр бүлийн тухай хууль
- III. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- IV. Эрүүгийн хууль
- V. Захиргааны хариуцлагын тухай хууль
- VI. Хүүхдийн эрхийн конвенци

8. Нэр томъёоны тайлбар

## 1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

### **Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний төрөл ангилал**

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь нийгмийн сэтгэл зовоосон асуудлын нэг мөн бөгөөд нийгмийн бүхий л хүрээнд өөрөөр хэлбэл гэр орон, сургууль гэх зэрэг хүүхдийн хамгийн ойр дотны халуун дулаан уур амьсгалтай байх ёстой газруудад тэдний эсрэг хүчирхийлэл үйлдэгдэж байдаг.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд тэдний эцэг эх, асран хүмүүжүүлэгчид зэрэг хэн нэгэн хүний зүгээс биеийн хүч, давуу талаа ашигласан үйлдлүүд багтдаг. Эдгээрийн үйлдлүүдийн үр дүнд хүүхдийн сэтгэл санаа, бие махбодид ямар нэгэн гэмтэл бэртэлт, өвчин, өвдөлт үүссэнээр тодорхойлогддог.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нилээн өргөн хүрээнд авч үзэх ёстой. Ялангуяа хүүхэдтэй ажилладаг Цагдаагийн ажилтнуудын хувьд дараах таван үндсэн хэлбэрийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай.

Үүнд:

1. **Үл ойшоох буюу хайхрахгүй байх явдал:** Энэ нь эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдээ асран хамгаалах ёстой үүргээ гүйцэтгэхгүй, ухамсарлахгүй байхтай холбоотой. Өөрөөр хэлбэл хүүхдийн оюун санаа, бие бялдрын хөгжил, түүний эрүүл мэндийг хамгаалах зэрэгт авах ёстой арга хэмжээнүүдийг авахгүй хайхрахгүй байгаагаар илэрхийлэгдэнэ.
2. **Асран хамгаалагчгүй орхих, үлдээх:** Үүнд эцэг эх ажилдаа болон амралтаар явахдаа хүүхдээ гэрт нь ганцааранг нь орхих явдлууд хамраарагдана. Үүнийг гэртээ ганцаараа үлдэх тохиолдол хэмээн нэрлэх бөгөөд энэ тохиолдолд хүүхэд тодорхой асрамж хамгаалалтгүй үлдэхийг хэлнэ.
3. **Бие махбодийн хүчирхийлэл:** Энэ нь томчууд, эцэг эхчүүд өөрсдийн давуу талаа ашиглан хүч хэрэглэж хүүхдийн бие махбодийг өвтгөх, түүнд гэмтэл учруулахыг хэлэх бөгөөд энэ тохиолдолд хүүхэд өөрийгөө хамгаалах ямар ч арга хэмжээ авч чаддаггүй. Жишээбэл: цохих, зодох,
4. **Сэтгэл санааны хүчирхийлэл:** Энэ төрлийн хүчирхийлэл нь хүүхдийн өөрийн үнэлэмж, түүний сэтгэл санааны хөгжилд сөрөгөөр нөлөөлдөг бөгөөд үүнд хэл амаар доромжлох, нэр хоч өгөх элдэвлэх, гадуурхах, үл ойшоох зэрэг үйлдлүүд багтана. Энэ нь нөгөө талаас хүүхдийн сэтгэл санааны хөгжил өсөлтөнд зайлшгүй шаардагддаг, тус дэм үзүүлдэг хайр халамж, энхрийлэл, тусламж дэмжлэг үзүүлэхгүй байхыг хэлнэ.
5. **Бэлгийн хүчирхийлэл:** Томчуудын зүгээс хүүхдийг айлган сүрдүүлж, албадан, хүч түрэмгийлэх замаар шууд болон шууд бус замаар бэлгийн ямар нэгэн төрлийн харилцаанд татан оролцуулах үйлдэлүүдийг хэлнэ.

Томчуудын зүгээс гадна хүүхдүүд өөрсдөө бие биенийхээ эсрэг албадан хүчээр бэлгийн харилцаанд татан оролцуулах явдлыг хамааруулан ойлгоно. Үүнд зөвхөн бэлгийн харьцаанд орсон тохиолдлыг бус завдах үйлдлүүдийг ч хамааруулдаг.

Хүчирхийллийн эдгээр хэлбэрүүд нь бүгд хүүхдийн бие махбод, сэтгэл санааны аль алинд нь сөрөгөөр нөлөөлж, ноцтой гэмтэл учруулж зарим тохиолдолд үхэлд ч хүргэх аюултай.

### **Хохирогчийн эрх, үүрэг, сэтгэлзүйн онцлог**

### **Хохирогчоос мэдүүлэг авах өрөөг ашиглах**

### **Хүчирхийлэлд өртсөн хүүхдээс мэдүүлэг авахад цагдаагийн ажилтны баримтлах зарчим**

3. Биеийн хүчний хүчирхийлэл, илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт
  - 3.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур
    - анхны уулзалт, ярилцлага
    - хэргийн талаар ярилцах
    - гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
    - хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
    - цаашид авах арга хэмжээг төлөвлөх
  - 3.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа
  - 3.3. ОУ-ын хууль тогтоомж

## **БҮЛЭГ 3**

### **Бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт**

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь насанд хүрсэн хүмүүс хүүхдийг албадан, хүч хэрэглэх замаар бэлгийн харьцаанд татан оролцуулах ганц удаагийн үйлдэл буюу давтан үйлдлүүдийг хамааруулна. Эдгээр үйлдлүүд нь хүүхдэд нөхөж баршгүй их бие болон сэтгэлийн гарз хохирлыг учруулдаг бөгөөд зарим онцгой тохиолдолуудад үхэлд ч хүргэдэг.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь ихэнх тохиолдолд тэдний ойр дотны хүмүүсийн зүгээс болон ахуйн хүрээнд ихээр үйлдэгдэж байгаа гэмт хэрэг бөгөөд үүнээс гадна хүүхдийн биеийг нь үнэлүүлэх, хил дамнуулан худалдаалах, порнографи, секс туризм гэх зэргээр зохион байгуулалттайгаар сексийн зорилгоор ашиглаж байгаа явдал ч нилээн газар авч байна.

Хүүхэд насанд хүрэгсэдийн зүгээс үйлдэгдэж байгаа эдгээр үйлдлүүдийг эсэргүүцэх, таслан зогсоох мэдлэг мэдээлэл, хүчин чадал, нийгмийн байр суурь байхгүй гэдгийг ойлгох нь чухал. Хүүхдийг албадан хүч хэрэглэн бэлгийн харьцаанд татан оролцуулсан бүх үйлдлүүд нь түүнийг үйлдэгчийн нас, нийгмийн байр суурийг харгалзахгүйгээр хүний эрхийг зөрчсөн үйлдэлд тооцогдох ёстой.

Сүүлийн жилүүдэд олон нийтийн зүгээс хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг ноцтой гэмт хэрэг бөгөөд ихээхэн газар авч байгаа асуудал болж байна гэдгийг нь хүлээн зөвшөөрөх, ойлгох хандлага нэмэгдэж байна.

Гэвч энэ төрлийн хүчирхийлэлтэй тэмцэх, үүнтэй холбоотой хэргүүдийг шийдвэрлэх мэргэжлийн бүлгүүдийн энэ талаарх ойлголт, хандлага тэр бүр сайн байж чадахгүйтэй холбоотой үүний эсрэг зохион байгуулалттай, үр дүнтэй тэмцэж чадахгүй байна.

### **3.1. Хүчингийн гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн халдлагын ялгаа**

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь цагдаагийн ажилтнуудын хувьд шийдвэрлэх, ажиллахад хамгийн хүндрэл бэрхшээлтэй хэргийн нэг байдаг. Энэ төрлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хүндрэл бэрхшээл учруулдаг гол шалтгаан бол хуулийн системийнхэн энэ чиглэлээр үр дүнтэй, зохион байгуулалттай арга хэмжээ авдаггүй, хохирогчдыг хамгаалах тэдэнд нөхөн төлбөр үзүүлэх тогтолцоо байдаггүйтэй холбоотой. Үүнээс гадна цагдаагийн ажилтнууд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тодорхой ойлголтгүй байдаг.

Зарим орны цагдаагийн байгууллагууд энэ төрлийн гэмт хэрэг дээр ажиллах тусгай ажилтан, экспеертүүдтэй байдаг. Гэвч цагдаагийн ажилтнуудыг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, энэ чиглэлээр ажиллахад нь мэргэшүүлэн сургах, бэлтгэхэд маш их зардал шаарддаг учир тэр бүр боломжгүй юм.

Иймээс бүх шатны ажилтанууд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн хэргийг таньж мэдэх, мөрдөн байцаах, шийдвэрлэх, хариу үйлдэл үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно. Тиймээс цагдаагийн ажилтанууд энэ төрлийн хэрэгтэй холбоотой гомдол хүлээн авсан тохиолдолд ямар арга хэмжээ авах, хэргийг илрүүлэх таньж мэдэх шинж тэмдгүүдийг мэддэг байх бөгөөд хохирогчидтой хэрхэн харьцах, тэднээс мэдүүлэг, мэдээлэл авах тусгай үр чадварт суралцсан байх нь хамгийн чухал юм.

Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн хэрэгтэй танилцсаны дараа цагдаагийн ажилтнууд хамгийн түрүүнд хохирогч хүүхэдтэй холбоо тогтоох, уулзах шаардлагатай болдог. Энэ тохиолдолд цагдаагийн ажилтнууд тэдэнтэй маш болгоомжтой, тэднийг хүндлэх замаар харьцах хэрэгтэй учир нь тэднийг дахин сэтгэл санааны дарамтанд оруулахаас урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчтой ажиллахад хүрвэл цагдаагийн ажилтанууд үүнийг л хамгийн түрүүнд анхаарах хэрэгтэй.

Хохирогч хүүхдүүд сэтгэл санааны хувьд маш эмзэг, мэдрэмтгий болсон байдаг. Ийм ч учраас цагдаагийн ажилтануудад сэтгэл судлаач, зөвлөгчид, нийгмийн ажилтнууд, шүүгч, прокуроруудтай нягт хамтран ажиллах шаардлага бий болдог.

Цагдаагийн ажилтан хэдийгээр ажлын сайн туршлага, арга барилтай байсан ч практик дээр дан ганц мэргэжлийн бүлэг нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэрэг тус бүрийг үр дүнтэй, бүрэн гүйцэд шийдвэрлэж чаддаггүй гэдэг нь харагдаж байдаг. Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шийдвэрлэхэд цагдаагийн ажилтнууд бусад мэргэжлийн бүлгүүдийн туслалцаа дэмжлэгийг авах, тэдэнтэй хамтрах нь хамгийн үр дүнтэй цогц арга болж байна.

Цагдаагийн байгууллага мэргэжлийн бусад бүлгүүдтэй хамтран ажиллахад хэд хэдэн давуу талууд байдаг. Жишээлбэл бусад мэргэжлийн бүлгүүдийн зөвлөгөө, саналууд нь цагдаагийн ажилтнуудад хэргийг олон талаас нь харахад тусладаг.

Түүнчлэн хүүхдийн чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдтэй зөвлөлдснөөр цагдаагийн ажилтан хүүхдийн нас, онцлогт тохируулан хэрхэн харьцах талаар илүү мэдлэгтэй болно. Энэ нь цагдаагийн ажилтан хохирогч хүүхдээс мэдүүлэг, ярилцлага авах арга техникээ сайжруулах болон үндэслэлтэй баримт, нотолгоо цуглуулахад нь туслана.

*Мэргэжлийн бусад бүлгүүдийн оролцоо, зөвлөгөө нь хохирогч хүүхдээс дахин дахин давтан мэдүүлэг авах, олон удаа яриулах явдлыг багасгах ингэснээрээ хохирогчийг сэтгэл санааны дарамтанд оруулах, сэтгэлийн шархыг нь сэдрээхээс урьдчилан сэргийлэх боломжтой болох юм.*

Түүнчлэн мэргэжлийн бүлгүүдээс туслалцаа авснаар хохирогч хүүхдүүдийн сэтгэл зүй, бие махбодид гарч болох аливаа сөрөг шинж тэмдэгүүдийг жишээлбэл сэтгэл санааны гүн хямралд орох, эмх замбараагүй хооллох, амиа хорлохыг завдах зэрэг байдлуудыг таньж мэдэхэд чухал ач холбогдол юм.

Цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхдээ бусад үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн бүлгүүдтэй хамтран ажиллаж олон талын арга хэмжээ авч байгаа нь сүүлийн үед хамгийн сайн арга болж байгаа нь олон ороны практик дээр батлагдаж байна.

Төрийн бус байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн бүлгүүдтэй хамтран ажиллах нь цагдаагийн хариу үйлдэл болон түүний үр дүн, чанарыг мэдэгдэхүйцээр дээшлүүлдэг байна.

**Жишээлбэл:** Хүйсийн тэгш эрхийн төв нь Дэлхийн зөн–Монгол Олон Улсын Байгууллагын Хүнд нөхцөл дэх хүүхэд хөтөлбөртэй хамтран Баянзүрх, Сонгинохайхран дүүргийн Хүүхдийн тасаг дээр Хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөөг байгуулан ажиллуулж байна. Уг өрөө нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдээс мэдүүлэг авах бөгөөд тухайн хэрэг дээр мэргэжлийн бүлгийн гишүүдээс бүрдсэн баг хамтран ажилладаг. Ингэснээр бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдээс ярилцлага, мэдүүлэг авах өрөөг байгуулан ажиллуулснаар хохирогч болсон хүүхэд дахин сэтгэлзүйн дарамтанд орохгүй, тухайн хэргийнхээ талаар дахин санахгүй байхад чухал юм.

Тусгай зориулалтаар бэлтгэсэн эдгээр өрөөнүүд нь хүүхдэд таатай дулаан уур амьсгал бүрдүүлэхээр тохижуулагдсан бөгөөд энэ нь хохирогч хүүхдүүдээс мэдүүлэг авах түүнтэй хийх ярилцлага зэргийг ихээхэн хөнгөвчилж өгдөг болохыг цагдаагийн ажиллагсад илэрхийлж байсан.

Ийм өрөөтэй болсноор хүүхдийн байцаагч болон хүүхдийн хэрэг дээр ажилладаг байцаагч нарт зориулсан сургалтуудыг шат дааралан авч хэрэгжүүлж байна. Мөн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг дээр дан ганц цагдаагийн ажилтан ажиллаад үр дүнд хүрэхгүй учраас сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, өмгөөлөгч зэрэг мэргэжлийн бүлгүүдээс бүрдсэн баг бий болгон ажиллах ёстой юм.

### 3.2. Хүчингийн гэмт хэргийн үйлдэгдэх онцлог

- садист
- догшин
- хуурч мэхлэх

### 3.5. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн хэргийн талаар мэдээлэл авах, хохирогч хүүхдээс мэдүүлэг авах, түүнтэй ярилцлага хийх нь цагдаагийн ажилтан, хохирогч хүүхэд аль алинд нь маш төвөгтэй, эмзэг асуудал байдаг. Хохирогч хүүхэд маш их болгоомжилж, олон талаар бодож үзсэний эцэст цагдаагийн байгууллагад хандах алхамыг хийдэг.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд сэтгэл санааны хувьд маш их гүн цочролд орсон байдаг. Ийнхүү цочрол, хямралтай үедээ цагдаагийн байгууллагад ханддаг учраас цагдаагийн ажилтнууд хохирогч хүүхдүүдтэй маш болгоомжтой, дэс дараалалтай харьцах хэрэгтэй бөгөөд тэдний ашиг сонирхолыг нэн тэргүүнд тавьж үзэх шаардлагатай. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг дээр ажиллаж байхдаа цагдаагийн ажилтнууд дараах *процедурыг* дагаж мөрдөх хэрэгтэй.

Уг процедурууд нь үндсэн *гурван үе шаттай*.

Үүнд:

**1. Таньж мэдэх, судалгаа явуулах ярилцлага**

Энэ нь хохирогчтой уулзах хамгийн анхны уулзалт бөгөөд энэ уулзалт ярилцлагаар цагдаагийн ажилтан хохирогчид хэргийн мөн чанар, үндсэн нөхцөл байдлыг тандаж тэр талаар ойлголт авахыг зорьж судалгаа явуулдаг.

**2. Нэмэлт мэдээлэл цуглуулах**

хохирогчтой хийсэн анхны уулзалт ярилцлагын дараа цагдаагийн ажилтан нэмэлт мэдээлэл цуглуулах ажилд орох ёстой бөгөөд хохирогчийн гэр бүлийн гишүүд, найз нөхөд, асран хүмүүжүүлэгчид зэрэгтэй уулзаж ярилцах замаар мэдээлэл цуглуулна. Ингэсний дараагаар шүүхийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэргэжилтэн зөвлөхүүдтэй уулзаж ярилцаж зөвлөлдөх ёстой.

**3. Дараагийн шатанд ямар арга хэмжээ авах шаардлагатайг шийдэх**

Дээрх хоёр процессын дараа цагдаагийн ажилтан хохирогчтой уулзаж ярилцах хоёр дахь удаагийн уулзалтыг зохион байгуулах хэрэгтэй бөгөөд цаашид авах арга хэмжээний талаар хохирогчтой ярилцаж, шийдэх ёстой.

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

**Ярилцлага хийх болон мэдүүлэг авах процедур ба практик жишээнүүд:**

*Хохирогчтой уулзаж хэргийн талаар үндсэн мэдээлэл авах, судлах анхны ярилцлага*

Энэ нь хохирогчтой хийх анхны уулзалт бөгөөд энэ уулзалт ярилцлагаар цагдаагийн ажилтан хэргийн бодит байдлын талаар олж мэдэх, тэр тухай аль болох их мэдээлэл авахыг хичээх хэрэгтэй бөгөөд ингэснээрээ хүүхдээс дахин дахин мэдүүлэг авах, түүнийг илүү их сэтгэлийн хямралд оруулахаас зайлсхийж чадна. Энэ процесс нь дараах үе шатуудтайгаар явагдах ёстой.

Үүнд:

*А. Уулзаж ярилцах*

*Б. Хэргийн талаар яриулах*

*В. Гэр бүлийнхэн нөхцөл, уур амьсгал, харилцаанд анализ хийх*

*Г. Хохирогч юу хүсэж, цагдаагийн ажилтнуудыг ямар арга хэмжээ авахыг хүсэж байгааг нь олж мэдэх*

*Д. Цаашид авах арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэн шийдвэрлэх*

**1. Уулзаж ярилцах**

Энэ үе шат нь мэдүүлэг авах болон ярилцлага хийх цаашдын үр дүн, чанарыг тодорхойлдог гэдгийг санаж байх хэрэгтэй. Үүнээс олон зүйл шалтгаална. Энэ үе шатны гол зорилго нь хохирогчтой холбоо тогтоох, танилцах болон түүнд итгэл найдвар төрүүлж өөрт нь тохиолдсон хэргийн талаар нь дэлгэрэнгүй яриулах, сэтгэлээ нээн ярилцах үндэс суурийг нь тавихад оршдог.



## 2. Хэргийн талаар яриулах

Анхны холбоо тогтоож, танилцсаны дараа хохирогч хүүхдэд өөрт нь тохиолдсон явдлыг өөрийн дүрслэл, хэмнэлээрээ ярих боломжийг олго. Түүнээс хэтэрхий дэлгэрэнгүй болон ямар нэгэн дэс дараатай ярихыг бүү шаард. Өөрийнхөөрөө ярьж дуусгах боломж олго. Хүүхэд ярьж дууссаны дараа дараагийн асуултуудаа тавь. Сэтгэлийн хөдөлгөөнөө хэтэрхий ил өүү гарга.

## 3. Гэр бүлийнхэн уур амьсгал, харилцаанд анализ хийх

Гэр бүлийнхэн уур амьсгал, гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны талаар тодорхой мэдээлэл авахыг хичээ.

## 4. Хохирогч юу хүсэж байгааг олж мэдэх

Энэ шатанд хохирогч цагдаагийн ажилтанг юу хийхийг хүсэж, цагдаагийн байгууллагын хариу үйлдэлээс юуг хүсэн хүлээж байгааг нь олж мэдэх хэрэгтэй.

## 5. Цаашид авах арга хэмжээнүүдийн талаар ярилцах, шийдэх

Хохирогчид цаашид ямар арга хэмжээнүүдийг авах шаардлагатай талаар сайтар ойлгуулж ямар учраас эдгээр архамууд чухал болохыг тайлбарлаж өгөх хэрэгтэй. Энэ нь ихэвчлэн хохирогчийн гэр бүлийн гишүүд, танил, найз нөхөдтэй нь уулзаж ярилцах болон бусад мэргэжлийн бүлгүүдийн төлөөлөгчтэй уулзаж, зөвөлгөө авах процессууд багтана.

### 3.6. Хүчингийн гэмт хэрийн хохирогчдод үзүүлэх туслалцаа

6. Сэтгэл санааны, үг хэлээр доромжлох хүчирхийлэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт

### 4.3. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

### 4.4. Хохирогчдод үзүүлэх туслалцаа

7. Эдийн засгийн болон гэр бүлийн хүчирхийллийн илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт

### 8.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур

- анхны уулзалт, ярилцлага
- хэргийн талаар ярилцах
- гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
- хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
- цаашид авах арга хэмжээг төлөвлөх

- 8.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа
9. Үе тэнгийнхний дарамт илрэл, таньж мэдэх арга болон хууль эрхзүйн зохицуулалт
- 9.1. Хохирогчоос мэдүүлэг авах болон ярилцлага хийх процедур
- анхны уулзалт, ярилцлага
  - хэргийн талаар ярилцах
  - гэр бүлийн уур амьсгал, харилцаанд анализ хийх
  - хохирогчийн юу хүсэж байгааг нь олж мэдэх
  - цаашид авах арга хэмжээг төлөвлөх
- 9.2. Хохирогчдод үзүүлэх туслалцаа

#### **4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэдтэй ярилцлага хийх, мэдүүлэг авах арга техник**

##### **Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллахдаа Цагдаагийн ажилтануудын зүгээс гаргадаг алдаанууд...**

Хохирогч хүүхэдтэй ярилцах, мэдүүлэг авах харьцахдаа анхаарах, болгоомжилвол зохих хэд хэдэн зүйлүүд байдаг. Эдгээрийг анхааралдаа аваагүйгээс болж олон алдаануудыг гаргадаг.

Үүнд:

**Нэгдүгээрт:** Мэдүүлэг авах явцад шаардлагатай бүх асуултуудаа ямар дарааллаар, хэрхэн ямар замаар тавих вэ гэдэгтэй холбоотой асуудал байна. Зарим зүйлийг мэдүүлэгийн эхэнд зарим зүйлийг нь хамгийн сүүлд ярих нь өөрт нь хялбар санагдах нь хүн бүрт өөр өөр байдаг.

**Хоёрдугаарт:** Хамгийн түгээмэл гаргадаг алдаа бол мэдүүлэгийг /ярилцлагыг/ хөтлөн явуулах хэлбэр, арга замыг сонгохдоо анхаарахгүй байх явдал байдаг. Асуулт асууж байгаа байдал, хэв маяг бүрт хүүхдийн сэтгэл хөдлөл өөр өөрөөр илэрдэг.

Цагдаагийн ажилтнууд дээрх хоёр зүйлийг нь аль алинийг нь анхааралдаа авч чадвал хохирогч хүүхдээс мэдүүлэг авах, түүнтэй ярилцлага хийх ажлыг амжилттай явуулж чадна.

##### **Үндсэн санамжууд**

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч бага насны хүүхэдтэй ажиллаж байхдаа цагдаагийн ажилтнууд тэдний нас болон хөгжлөөс шалтгаалан хэд хэдэн зүйлүүдийг санаж байх хэрэгтэй. Хүүхэд нас, сэтгэлзүйн зэрэг онцлогуудаас шалтгаалан аливаа зүйлийг дүрслэн ярих болон анхаарлаа төвлөрүүлэх төвшин нь өөр өөр байдаг.

Тухайн хүүхдийн нас, онцлогт тохируулан хэрхэн ярилцах, харьцахаа мэдэхгүй бол мэдүүлэг, ярилцлага үр дүнтэй амжилттай болж чадахгүй. Ямар нэгэн насны хүүхэдтэй ярилцаж байхдаа тэд аливаа үйлдэл, биеийн хэсгүүдийг ямар үг хэллэгээр илэрхийлж байгааг тусган авч тэр үг хэллэгийг нь ашиглавал хүүхдэд хялбар байдаг. Зарим тохиолдолд үг хэллэгүүд нь ямар утгатайг хүүхдээс асууж тодруулж болох бөгөөд нэгэнт ойлгомжтой болсон тохиолдолд хүүхдийг өөрийнхөө үг хэллэг, дүрслэлээрээ ярихыг нь зөвшөөр.

**Анхаар** Эрэгтэй цагдаагийн ажилтан ганцаараа хохирогч хүүхэдтэй ярилцлага хийх, мэдүүлэг авах ёсгүй. Боломжтой бол энэ ажлыг эмэгтэй цагдаагийн ажилтан гүйцэтгэх хэрэгтэй. Энэ нь дараах хоёр шалтгааны улмаас чухал юм.

Үүнд:

Ихэнх тохиолдолд бэлгийн хүчирхийлэл үйлдэгч нь эрчүүд байдаг бөгөөд, эрэгтэй/ эмэгтэй хүүхдийн аль аль нь сэтгэлзүйн хувьд ганцаараа эрэгтэй хүнтэй үлдэхээс маш их айдаг. Ер нь ихэнх тохиолдолд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд өөрийн таних, танихгүй бүх эрэгтэй хүмүүсээс айх, тэдэнд итгэх итгэлгүй болсон байдаг.

Тиймээс тэдэнд өөрсдөдөө тохиолдсон зүйлээ ярих, цагдаад мэдэгдэх бүрэн боломжийг олгох үүднээс үүнийг анхаарах хэрэгтэй. Эрэгтэй цагдаагийн ажилтан ганцаараа хохирогч хүүхэдтэй уулзаж ярилцах, мэдүүлэг авах тохиолдолд таны бодож байгаа шиг амжилтанд хэзээ ч хүрэхгүй.

Хүүхэд аливаа сар өдөр хугацааг нарийн тодорхой санадаггүй бөгөөд харин тэр үед цаг агаар ямар байсан, тэр нь хэн нэгний төрсөн өдөртэй ойролцоо байсан, ямар хичээлтэй өдөр байсан гэх мэтээр асуувал илүү мэддэг.

Хүүхэдтэй ярилцах, мэдүүлэг авах өрөө нь хүүхдэд дулаан уур амьсгал төрүүлэхүйц тав тухтай байх ёстой. Үүнийг та маш хялбар арга замаар хийж болох бөгөөд жишээлбэл уг өрөөнд янз бүрийн тоглоомууд байрлуулж, хүүхдийн дуртай өнгөтэй зүйлүүдийг тавих, гоё зураг, чимэглэлүүдийг хананд нь байрлуулснаар та тэрхүү уур амьсгалыг бүрдүүлж чадна.

Эдгээр нь хүүхдийн айдасыг багасгахад тусалдаг бөгөөд хүүхдэд илүү итгэлийг төрүүлдэг. Ингэснээр хүүхэдтэй ярилцлага хийх болон мэдүүлэг авах үйл явцыг хялбар болгож, амжилттай явуулахад нөлөөлж чадна.

Энэ бүхний дараа хохирогчтой хоёр дахь удаагаа уулзаж ярилцах хэрэгтэй.

Хохирогчийн анх удаа уулзаж ярилцлага хийхдээ түүнээс хэтэрхий дэлгэрэнгүй ярихыг албадах, олон асуултууд асуухаас зайлсхийх хэрэгтэй бөгөөд хохирогчид өөрөө л ярихыг хүсэж байгаа зүйлийг нь л ярих боломж олгох хэрэгтэй.

Анх удаагийн уулзалт ярилцлагаар бүх зүйлийг мэдэж авахыг зорих нь чухал биш түүнийг байцаалтын явцад дэлгэрүүлж болно.

Энэ үед анхаарах гол зүйл бол хохирогчийг шавдуулахгүй байх, хэт олон болон дэлгэрэнгүй яриулах асуултуудыг тавихгүй байх, хохирогчийн ярьсан зүйлд сэтгэлийн хөдөлгөөнөө үг яриагаар болон үйл хөдлөл, нүүр царайны байдлаар хэт ил илэрхийлэхгүй байхыг хичэх хэрэгтэй.

### **Case:** Практик жишээ

Уг практик жишээнд бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй уулзаж ярилцахад юуг анхаарах вэ, юун дээр цагдаагийн ажилтнууд их алддаг вэ? гэдэг асуултуудыг гарган харуулахыг зорьсон юм. Мөн уулзалт ярилцлага мэдүүлэгийг дээр дурдсан процедурын дагуу хэрхэн явуулах вэ гэдгийг олж харж болно.

Уулзалтыг голчлон цагдаагийн эмэгтэй хөтлөн явуулж байгаа бөгөөд мэдээж хохирогч охины хувьд сэтгэл санааны хувьд маш тавгүй, айсан, сандарсан байдалтай байгаа нь харагдаж байгаа. Ярилцлагад хэрэглэж байгаа үг хэллэгүүд ихээхэн анхаарал тавих хэрэгтэй.

### *А. Холбоо тогтоох танилцах уулзалт ярилцлага*

14-15 орчим насны охин нэгэн эмэгтэйтэй хамт цагдаагийн газар ирнэ.

- Цагдаагийн жижүүр: Сайн байцаана уу? Та нарт юугаар туслах вэ?
- Эмэгтэй: Сайн. Сайн байна уу? Бид нар хэн нэгэн хүнтэй уулзаж ярилцах хэрэгтэй байна.
- Цагдаагийн жижүүр: Магадгүй би тус болж болох юм.
- Эмэгтэй: Тайлбарлахад жаахан төвөгтэй байна. Бид хоёр хэн нэгэн хүнтэй биечлэн уулзаж аминчлан ярилцах хэрэгтэй байгаа юм л даа. Бид хоёр.....хэлтэсээс хэн нэгэн хүнтэй уулзаж болох уу?
- Цагдаагийн жижүүр: Бололгүй яахав. Та 2 түр суугаад хүлээж байхгүй юу? Би утсаар яриад та 2-ыг холбогдох хүмүүстэй нь уулзуулаад өгье.
- Эмэгтэй: Их баярлалаа.

*Хэсэг хугацааны дараа цагдаагийн эмэгтэй, эрэгтэй хоёр ажилтан ирээд охин эмэгтэй хоёрыг уулзалтын өрөөнд урилаа.*

- Цагдаагийн эмэгтэй ажилтан: Өөрсдийгөө танилцуулахыг зөвшөөрнө үү? Бид ..... хэлтэст ажилладаг. Намайг Анна гэдэг. Энэ бол надтай хамт ажилладаг манай хэлтэсийн ажилтан Жонн.
- Анна: Та нар өөрсдийгөө танилцуулахгүй юу?
- Охин: Намаыг Мария Ферраро гэдэг, надтай хамт яваа хүн бол манай авга эгч, түүнийг Лена гэдэг.

Цагдаагийн эрэгтэй ажилтан тэдэнд уух юм авчирч өгнө.

- Анна: Бидний ойлгосноор та 2 манай хэлтэсээс хүмүүстэй тусгайлан уулзаж ярилцахыг хүссэн гэсэн.
- Лена: Тиймээ.
- Жорж: Тэгэхээр бүгдээрээ ярилцаж эхлэхээс өмнө нэг асуулт байна. Та хоёр зөвхөн манай эмэгтэй ажилтантай ярилцахыг хүсэж байна уу? Хэрвээ та бүхэн тэгж хүсэж байвал би ойлгоно.
- Охин: Зүгээрээ.
- Жорж: Чи итгэлтэй байна уу?
- Охин: Тиймээ.
- Анна: Би асуух зүйл байвал асуугаад явъя. Жорж тэмдэглэл хөтлөнө, та хоёр дургүйцэхгүй биз дээ.
- Охин: Үгүй ээ. Үгүй.
- Анна: Эхний асуулт, чи хэдэн настай вэ?
- Охин: 15
- Анна: Чи өөрт тохиолдсон явдлаа ярихыг хүсэж байна уу?
- Охин дуугүй суусаар байна. Түүний маш хүнд байгаа нь илт байна.
- Жорж: Бид нар чиний насны хүүхдүүдтэй ажилладаг. Магадгүй чи бидний талаар илүү зүйл мэдэхийг хүсэж байна уу?
- Охин: Үгүй. Үгүй.
- Анна: За тэгвэл чи бидэнд ярихыг хүсэж байгаа зүйлээ ярихгүй юу? Дараагаар нь бүгдээрээ хамтдаа асуудлыг шийдэхэд юу хийж чадахаа ярилцъя тэгэх үү?
- Охин: За...

## *2. Хэргийн талаар яриулах ярилцлага*

- Анна: Чи бидэнд юу ярихыг хүссэн юм вэ? Чамд хүнд байгаа гэдгийг бид ойлгож байна.
- Охин: Би сая гэрээсээ ирсэн. Аав уурлаж хашгичаад намайг гэрээсээ хөөсөн. Би маш их цочирдсон.
- Аав чинь юунаас болоод тэгтлээ их уурласан юм бол?
- Бүх зүйл миний эрэгтэй найз Дэвидээс болсон. Манай аав түүнийг маш их үзэн яддаг. Түүнийг гэртээ орохыг ч зөвшөөрдөггүй.
- Анна: Аав чинь түүнийг яагаад тэгтлээ их үзэн яддаг юм бол?

- Охин: Мэдэхгүй ээ. Аав угаасаа намайг хэн нэгнийг гэртээ дагуулж ирэхэд их дургүй байдаг. Магадгүй гадны хүмүүсийг гэртээ оруулахад дургүй байдаг байх. Гэхдэ Дэвидийг яагаад тэгж үзэн яддагыг би үнэхээр мэдэхгүй байна.
- Анна: Чи найз Дэвидийнхээ талаар бидэнд ярьж өгөхгүй юу?
- Охин: Манай сургуулийн хүүхэд, бид 2 хэдэн сарын өмнөөс уулзаж үерхдэг болсон. Харин би сүүлийн үед түүнтэй уулзаагүй. Өнгөрсөн долоо хоногийн нэг өглөө аав дөнгөж ажлаасаа ирээд байж байсан юм. Тэр Дэвидийн надад бичсэн захиаг олоод уншчихсан байсан.
- Анна: Аав чинь тэгээд яасан вэ?
- Охин: Тэр над руу орилж хашгийчаад намайг загнаж харааж эхэлсэн.
- Анна: Аав чинь яагаад тэгтлээ их уурлсан гэж бодож байна вэ?
- Охин: Мэдэхгүй ээ. Намайг Дэвидтэй хамт байхад л тэр маш их дургүйцдэг, яагаад тэгдэгийг нь би ойлгодоггүй. Би түүний гаргадаг зан авираас маш их айж, санаа зовж байна. Зөвхөн өөрөө өөртөө бус Блэндад ч гэсэн маш их санаа зовж байна.
- Анна: Бленда гэдэг чинь хэн юм вэ?
- Охин: Миний эмэгтэй дүү.
- Анна: Тэр хэдэн настай вэ?
- Охин: 10
- Анна: Аав чинь тэгээд Дэвидийн захидлыг олоод уурласан гэсэн, чи тэгэхэд нь яасан бэ?
- Охин: Би Дэвид рүү утасдсан. Аз болоход тэр гэртээ байсан. Тэр хичээлээ таслаад манай авга эгч Ленагийн гэр рүү очиж уулзахыг санал болгосон.
- Анна: Лена эгч чинь танай аавын чинь эгч үү, ээжийн чинь эгч үү?
- Лена: Би аавынх нь эгч юм аа.
- Охин: Лена эгч бүх зүйлийг мэдэж байгаа, би түүнд бүгдийг ярьсан.
- Анна: Чи дээр би дүүдээ маш их санаа зовж байна гэж хэлсэн. Тэр тухайгаа ямар нэгэн юм ярих уу?
- Охин: Би түүнд үнэхээр их санаа зовж байна. Ялангуяа түүнийг аавтай хоёулахнаа хоцроход... Би түүнд ямар нэгэн муу зүйл бүү тохиолдоосой гэж задбирч байна.
- Анна: Яагаад? Юу тохиолдож магадгүй гэж чи бодож байгаа юм бэ?
- Охин: Яагаад гэвэл би аавыг заримдаа түүн рүү харж байгаа харцын харахаараа айдаг. Би түүнийг дотроо юу бодож байгааг би мэдэж байна.
- Анна: Чи аавынхаа харцнаас юу бодож байгааг нь мэддэг гэж хэллээ.
- Охин: Тиймээ.
- Анна: Чи яаж мэддэг юм бэ? Тэр юу хүсдэг гэж?
- Охин: Тэр заримдаа над руу тийм харцаар хардаг, тэгэхэд нь би түүнийг надаас ямар нэгэн зүйл хүсээд байна гэдгийг нь мэдэрдэг.
- Анна: Чухам юуг хүсдэг юм бэ?
- Охин дуугүй сууна.
- Анна: Чиний хүсэхгүй байгаа зүйлийг тэр хүсдэг үү? Чамд энэ бүхнийг ярихад маш хэцүү байгаа гэдгийг чинь би мэдэж байна, гэвч бид чухам юу болоод байгааг мэдсний үндсэн дээр л чамд тохиолдсон асуудлыг

шийдвэрлэхийн тулд бүгдээрээ хамтдаа юу хийж чадах вэ гэдгээ ярилцана шүү дээ.

- Анна: Тэр секс хүсдэг үү?
- Охин: Тэр намайг өөрт нь хүрэхийг хүсдэг.
- Анна: Хаана нь хүрэхийг хүсдэг гэж?
- Охин: .....
- Анна: Түүний бэлэг эрхтэнд үү?
- Охин толгой дохино.

/ Энэ хэсэгт ингэж дэлгэрэнгүй асуухгүй байх нь дээр, энэ нь охиныг ямар хүнд байдалд оруулж байгааг нь ойлгомжтой, түүнэр заавал тийм дэлгэрэнгүй яриулахыг албадах хэрэггүй/

- Анна: За за одоо энэ тухай одоо би дахиад асуухгүй.
- Анна: Энэ байдал аль хир удаан үргэлжилж байгаа юм бэ?
- Охин: Намайг 12 настай байх үеэс
- Анна: Тэгээд одоо хүртэл үргэлжилсээр байгаа юм уу? Хэзээ хамгийн сүүлд тийм юм болсон бэ?
- Охин: Өнгөрсөн долоо хоногт байх.
- Анна: Энэ тухай ээж чинь мэдэж байгаа юу? Чи ээждээ хэлсэн үү?
- Охин: Би уг нь түүнд нэг удаа хэлэхийг оролдсон.
- Анна: Ээж чинь тэгээд юу гэсэн бэ?
- Охин: Эхэндээ тэр намайг шоолж инээгээд намайг бүх зүйлийг санаанаасаа зохиож байна гэж хэлсэн. Чамд л тэгж санагдаж байгаа юм гэсэн.
- Анна: Дараа нь яасан бэ?
- Охин: Би дахиад тайлбарлаж ойлгуулахыг хүссэн боловч бас л бүтэлгүй болсон. Энэ удаад ээж уурлаж эхэлсэн. Аав чинь бидэнд их хайртай, бидний төлөө ихийг хийдэг гэх мэтийн зүйлүүдийг ярьсан. Ийм учраас би түүнд дахин энэ тухай ярихыг оролдохоо больсон.
- Анна: Чамд итгээгүй юм болов уу?
- Охин: Мэдэхгүй, зүгэр л итгэхийг хүсэгүй байж магадгүй, итгэсэн ч тэр талаар юу ч хийж чадахгүй болохоороо намайг сонсохыг хүсэгүй байж болох юм.

### 3. Гэр бүлийнхэн нөхцөл байдлын талаар олж мэдэх

- Анна: За тэгэхээр одоо хоёулаа танай гэр бүлийнхний талаар жаахан ярилцах уу? Аав чинь ямар ажил хийдэг вэ?
- Охин: Тэр нэг байгууллагад шөнийн жижүүр хийдэг.
- Анна: Тэгэхээр аав чинь өдөр гэртээ их байдаг гэсэн үг үү?
- Охин: Тиймээ.
- Анна: Ээж чинь ямар ажил хийдэг вэ?
- Охин: Ээж эмнэлэгт сувилагч хийдэг.
- Анна: Шөнийн ээлжинд үү? Өдрийн ээлжинд үү?
- Охин: Янз янз байдаг.

- Анна: Аав ээж чинь их завгүй ажилладаг хүмүүс юм байна. Тэгэхээр аав ээжийг чинь эзгүйд та хоёрыг хэн халамжилдаг вэ?
- Охин: Манай авга эгч Лена. Тэднийх манайхтай ойрхон амьдардаг. Гэхдээ Лена эгч хүнсний дэлгүүр ажиллуулдаг болохоор тэр бүр завгүй.
- Анна: Охин дүү чинь чамаас нилээд хэдэн насаар дүү гэсэн. Дүүг чинь хэн халамжилдаг вэ?
- Охин: Ихэнх тохиолдолд би түүний өглөөний цайг бэлтгэж, сургуульд нь хүргэж авдаг. Аав ээж гэртээ байсан ч тэд маш их ядарсан байдаг болохоор би л дүүгээ халамжлах болдог.
- Анна: Танай авга эгчээс гадна чамд санаа тавьдаг, ойр дотно байдаг хүн бий юу?
- Охин: Манай тооны багш. Тэр маш сайн эмэгтэй. Тэр үргэлж намайг сонсож надад анхаарал тавьж байдаг.
- Анна: Чи өөрийнхөө асуудлыг багшдаа ярьсан уу?
- Охин: Яг ч бүх зүйлийг дэлгэрэнгүй яриагүй. Гэхдээ би нэг удаа Девидээс болоод аавтайгаа муудалцсан нэг өдөр багш надаас бүх юм зүгээр үү? Чамд ямар нэгэн юм тохиолдоогүй биз гэж асуусан. Тэр үед би уйлаад гэртээ юу болсон талаар ярьсан.
- Анна: Танай багш чинь үнэхээр сайн хүн юм аа. Чи багштайгаа ярилцах үед аавынхаа тухай хэлсэн үү?
- Охин: Үгүй ээ, би яг юу гэж хэлэхээ сайн мэдэхгүй байсан.
- Анна: за за ойлголоо.
- Анна: Чиний ердийн нэг өдөр яаж өнгөрдөг вэ? чи юу хийдэг вэ?
- Охин: Би өглөө 7 цагт босоод өглөөний цайгаа уугаад 8 цагийн үед Блендаг сургуульд нь хүргэдэг. Бидний хичээл өдөр 3:30 үед дуусдаг бөгөөд би Блендаг аваад гэртээ харьдаг. Долоо хоногийн тодорхой нэг өдрүүдэд дэлгүүр явж юм хум цуглуулдаг. Тэгээд би орой хоолоо хийж эхэлдэг. Манайх ер нь оройн хоолоо жаахан эрт иддэг, яагаад гэвэл аав маань орой 7:30 гэхэд ажил дээрээ очсон байх ёстой. Хооллож дуусаад Бленда бид хоёр гал тогоогоо цэвэрлээд дараа нь гэрийн даалгавараа хийдэг. Бид хоёр ихэвчлэн 10:30 үед унтдаг.
- Анна: Та хоёр тусдаа өрөөтэй юу?
- Охин: Тиймээ.
- Анна: Та хоёрыг эмчид очих хэрэгтэй болвол хэн аваачдаг бэ?
- Охин: Авга эгч Лена. Тэгэхдээ энэ бол нэг их үргэлж тохиолддоггүй.
- Анна: Чи хамгийн сүүлд хэзээ эмчид очсон бэ?
- Охин: Сайн санахгүй байна. Нилээн дээр үед миний нуруу өвдөөд эмчид үзүүлсэн.
- Анна: За. Бид нар чамд туслах чиний асуудлыг хамтдаа шийдвэрлэхэд шаардагдах тодорхой ойлголттой боллоо. Одоо чамаас асуух ганц л зүйл байна. Чи ямар учраас бидэнд хандах шийдвэр гаргасан бэ?
- Охин: Би бүх зүйлийг зогсоохыг хүсэж байна. Манай дүү Блендад тийм зүйл бүү тохиолдоосой хэмээн хүсэж байна.
- Анна: Маш сайн байна. Бүгдээрээ хамтраад юу хийж чадахаа үзье.

#### 4. Цаашид авах арга хэмжээний талаар ярилцах



- Эрэгтэй цагдаа Жорж: Бид өнөөдрөөс эхлээд хэд хэдэн хүнтэй уулзаж ярилцах хэрэгтэй байна. Магадгүй танай авга эгч Ленагаас эхэлж болох юм. Та түүнд цаг гаргаж чадах уу.
- Лена: Бололгүй яахав. Жорж: Дараагаар нь бид ээжтэй чинь бас уулзаж ярилцах хэрэгтэй байна. Чи энэ тухай юу гэж бодож байна?
- Охин: Сайн мэдэхгүй байна. Миний та нарт ярьсан зүйлд тэр итгэх болов уу? Мэдэхгүй, хэрвэ шаардлагатай юм бол...
- Жорж: Бид бас танай найз Дэвид, тооны багш хоёртой чинь уулзаж ярилцмаар байна. Энэ тухай чамд ямар санагдаж байна.
- Охин: Багшийн хувьд би түүнтэй нилээн дээр ярилцаж байсан болохоор багш тэр бүхнийг санах болов уу? Харин Дэвид бол манай авга эгч Ленагийн мэдэж байгаа зүйлүүдийг л мэднэ шүү дээ.
- Жорж: Тэгэхдээ бид хэн хэнтэй нь уулзаж ярилцах хэрэгтэй гэж бодож байна. Олон хүнтэй уулзаж ярилцах тусам бид нөхцөл байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой болох юм л даа. Ер нь бид эдгээр хүмүүстэй уулзаж ярилцахын гол зорилго бол нэмэлт мэдээлэл цуглуулахад байгаа юм. Эдгээр хүмүүстэй уулзаж ярилцсаны дараа бид зарим нэг мэргэжилтнүүдтэй уулзаж зөвөлгөө авах болно.
- Охин: Ямар мэргэжилтнүүд?
- Жорж: Хуульчид, сэтгэлзүйчид гэд чиний энэ тохиолдлоор маш их туршлагатай хүмүүстэй уулзаж, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тэдний саналыг сонсож зөвөлгөө авахыг хэлж байгаа юм л даа.
- Жорж: Энэ бүхний дараа бид чамтай эргээд уулзах болно. Мэдээж Лена та ч гэсэн оролцож болно. Түүнээс гадна хүүхэд хамгаалалын хэлтэсийн ажилтан нэг эмэгтэй бас оролцох болно. Тэр эмэгтэй бас бидэнтэй маш ойр хамтран ажилладаг.
- Жорж: Дараагийн удаа бид чамтай уулзахдаа юу юу хийсэн болон юу хийхээр төлөвлөж байгаа талаараа чамд мэдээлэл өгнө. Мөн тэдгээрийн талаар чиний санал бодлыг сонсоно. Тэгсний дараагаар бүгдээрээ хамтдаа шийдвэр гаргах болно. Бүх зүйлийг ойлгосон уу? Чамд асуух асуулт байна уу?
- Охин: Ойлголоо, асуух зүйл алга.

Хохирогч хүүхэдтэй уулзаж ярилцсаны дараа дараах үе шаттай ажлуудыг гүйцэтгэх хэрэгтэй. Эдгээрийг хохирогчтой уулзсаны дараа аль болох ойрын хугацаанд яаралтай хий.

Үүнд:

- А. Үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гаргах
- Б. Нэмэлт мэдээлэл цуглуулах
- В. Мэргэжилтэн, зөвлөхүүдэс зөвөлгөө авах

А. Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Хохирогч хүүхэдтэй уулзаж анхны ярилцлага хийсний дараа цагдаагийн ажилтнууд ямар арга хэмжээ авахаа хэлэлцэн цаашдын үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг гарга. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлийн гэмт хэрэгтэй

тэмцэхэд цагдаагийн ажилтнууд баг бүрдүүлж ажиллах нь илүү үр дүнтэй. Үйл ажиллагаагаа төлөвлөн ажилтан тус бүрт ажлыг нь хуваарил.

Тухайн хэргийг шийдэх хамгийн үр дүнтэй, хамгийн тохиромжтой арга замын талаар ярилцаж тохиролцсоны дараа нэмэлт мэдээлэл цуглуулах ажилд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нэмэлт мэдээллийг хохирогчийн ойр дотны хүмүүс болох гэр бүлийнх нь гишүүд, найз нөхөд, багш, хөршүүд зэрэг хүмүүстэй уулзаж ярилцах замаар цуглуулж болно.

Шаардлагатай нэмэлт мэдээлэлээ цуглуулсаны дараа мэргэжилтэн зөвлөхүүдтэй уулзаж зөвлөгөө авах нь чухал. Мэргэжилтэн зөвлөхүүд нь шүүгчид, хуульчид, тухайн хэргийг шийдвэрлэдэг цагдаагийн хэлтэсийн дарга, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын ажилтнууд зэрэг хүмүүс байж болно.

Тухайн нэг хэргийг шийдвэрлэхэд хамтран ажиллах, зөвлөгөө авах шаардлагатай мэргэжилтнүүдэд хэргийн талаар буюу хохирогчийн нөхцөл байдлын тухай мэдээлэл өгч хэргийг шийдвэрлэх хамгийн сайн үр дүнтэй стратегийн хувилбарыг санал болгохыг асуу. Эдгээр мэргэжлийн хүмүүс ялангуяа хэрэгтнийг шийтгэхэд олон хувилбарыг санал болгож чаддаг.

CASE:Дээрх практик жишээний үргэлжлэл буюу хохирогчтой уулзсаны дараа цагдаагийн ажилтнууд ямар алхам хийж буйтай танилцана уу.

#### A. Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

Эмэгтэй цагдаагийн ажилтан буюу Анна хамтран ажиллагч Жоржтой ярилцаж байна.

- Анна: Би хэргийн талаар ахмадад танилцууллаа. Тэгээд дараах арга хэмжээг авах хэрэгтэй гэж үзлээ. Эхлээд охины тооны багштай, дараа нь найз Дэвидтэй нь сүүлд нь ээжтэй нь уулзах, эдгээр хүмүүстэй уулзаж хэрэгтэй нэмэлт мэдээлэлээ цуглуулсаны дараа ахмадтай уулзаж зөвлөлдөх.
- Жорж: Би энэ чиглэлээр туршлагатай мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхүүдтэй холбоо барьж уулзаж ярилцъя.
- Анна: Сайн байна, тэгэхээр хэн юу хийх нь тодорхой боллоо.

#### Б. Нэмэлт мэдээлэл цуглуулах:

Нэмэлт мэдээлэл цуглуулахад зайлшгүй уулзах шаардлагатай хүмүүсээ тодорхойлсоны дараа тэдгээр хүмүүстэй холбоо барьж уулзалтыг зохион байгуулна.

#### В. Мэргэжилтэн зөвлөхүүдтэй зөвлөлдөх

Практик жишээ: Дээр дурьдсан хэрэг дэр энэ чиглэлээр хэрхэн ажиллаж байгаатай танилцана уу.

Анна: Бид таньд хэргийн талаар танилцуулсан. Иргэн Феррарог хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн хэргээр сэжиглэн шалгаж байгаа юм. Бид үдэс хойш хохирогч охины ээжтэй нь уулзаж ярилцах гэж байгаа. Бусад хэргэтэй гэж үзсэн хүмүүстэй уулзаж мэдээлэл авсан. Одоо бидэнд шийдвэр гаргахад хохирогч охин болон түүний эмэгтэй дүү Бленда нарын эрх ашгийг хамгаалсан хамгийн сайн сонголтыг боловсруулах шаардлага тулгараад байгаа юм. Тэгэхээр та нийгмийн ажилтан хүний хувьд ялангуяа хоёр охинд ашигтай байх ямар хувилбарыг бидэнд санал болгох вэ?

Нийгмийн ажилтан: Та бүхний авах арга хэмжээ хоёр охины амьдралд сөргөөр нөлөөлөхгүй, тэдний хэвийн амьдралд ямар нэгэн эмх замбараагүйдлийг бий болгохгүй байлгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл эцгийг нь баривчлах тохиолдолд хоёр охин ээжтэйгээ гэртэ амьдрах, өөрсдийн явдаг сургуульдаа явах нь хэвээрээ байх ёстой.

Миний ойлгосноор хоёр охин ямао нэгэн шууд аюул заналхийлэлд байхгүй байгаа юм байна. Тэгэхэр энэ тохиолдолд дээр дурьдсан зүйлүүдийг нэн тэргүүнд тавих хэрэгтэй.

Харин ээж нт охиныхоо ярьсныг хүлээн зөвшөөрөхгүй, итгэхийг хүсэхгүй байгаа гэсэн. Ээжийнх нь хувьд түүний нөхөр, охин хоёрын хооронд юу болсныг сайн мэдэхгүй эсвэл мэдсэн ч хайхрахгүй байгаа байж магадгүй. Тиймэс би ээжтэй нь уулзаж мэргэжлийн үүднээс зөвөлгөө өгч нөхцөл байдлыг ойлгох хүлээн зөвшөөрөхөд нь туслах хэрэгтэй гэж бодож байна. Мөн охины ээж нөхөрт нь ямар арга хэмжээ авбал дээр гэж бодож байгаа саналыг нь асуух хэрэгтэй. Дараа нь охинтой уулзаж түүний юу хүсэж байгааг болон энэ бүх зүйлийн талаар юу бодож байгааг нь сонсох хэрэгтэй байх гэж бодож байна.

*Цаашид хийх ажлаа шийдэхэд дараах үе шаттайгаар ажиллах хэрэгтэй. Үүнд*

*А. Нөхцөл байдлыг шалгах*

*Б. Мэдээлэл өгөх*

